



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

**“Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 125,638,375.00 (нэг зуун хорин таван сая зургаан зуун гучин найман мянга гурван зуун далан тав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 55,000,000.00 (тавин таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бямбасүрэн, хавсралтад заасан байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13300687
10-r_huraldaah.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны... дугаар сарын...ны/ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашин нэр, төрөл	Үйлдвэрлэгд сэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Автомашин хүлээн авах хуулийн этгээд
1	Toyota Ландкрузер- 200,	2008/2008	JJTMNHU09J305009619	0586 УБЗ	81,693,375.00	5	40,000,000.00	Хөшөө цайдам музей
2	Суудлын тэрэг /Nissan Sunny/	2013/2013	MDHVBAN17Z05000498	0667 УБР	43,945,000.00	5	15,000,000.00	Орхон аймаг дахь Мал эмнэлгийн газар
НИЙТ ДҮН					125,638,375.00		55,000,000.00	
					(нэг зуун хорин таван сая зургаан зуун гучин найман мянга гурван зуун далан таван төгрөг)		(тавин таван сая)	